



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



**БИЕЙН ТАМИР,
СПОРТЫН САЛБАРЫН
ТАНИЛЦУУЛГА**
2019 он

Улаанбаатар хот
2020 он

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАР

Танилцуулгыг хянасан:

Ч.Баянчимэг ҮСХ-ны Дэд дарга
А.Амарбал ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга
Н.Должинсүрэн ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын ахлах статистикч

Танилцуулгыг боловсруулсан:

Б.Ариунчимэг ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын статистикч
Цахим шуудангийн хаяг: ariunchimeg@nso.mn

Хаяг:

Засгийн газрын III байр, Бага тойруу -44, Улаанбаатар -11 Монгол Улс
Цахим хаяг: www.nso.mn, www.1212.mn, <https://mecss.gov.mn/>
Цахим шуудангийн хаяг: information@nso.mn, Info@mecs.gov.mn
Утас: 51-263966, 51-263600

АГУУЛГА

I.	БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	4
II.	УДИРТГАЛ	5
III.	БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	6
	III.1 Биеийн тамир спортын байгууллага, ажиллагчид, спортоор хичээллэгчид	8
	III.2 Цолтой тамирчид, шүүгч, дасгалжуулагчид	11
IV.	ДҮГНЭЛТ, ЦААШИД АНХААРАХ АСУУДЛУУД	14
V.	ХАВСРАЛТ 1 – ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	15
VI.	ХАВСРАЛТ 2 – ХҮСНЭГТҮҮД	16

I. БИЕЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2018	2019	Өсөлт, бууралт, %
Биеийн тамир, спортын байгууллага	42	40	4.8 ↓
Ажиллагчдын тоо	704	737	4.7 ↓
Спорт заал	1000	1016	1.6 ↑
Биеийн тамир, спортоор хичээллэгчид, мянган хүн	147.2	152.6	3.7 ↑
Цолтой тамирчид, дасгалжуулагчид	6773	2621	61.3 ↓
Цолтой шүүгчид	447	140	68.7 ↓



II. УДИРТГАЛ

БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

Дэлхийн улс орнуудын хөгжлийн түүхээс харахад эрт үеэс уламжлагдан ирсэн тоглоом, наадам, спорттой байдаг. Түүх судлаачид Монголын соёлын өвийн нэг болох эрийн гурван наадам нь Монгол Улсын спортын түүхэн эхлэл гэж үздэг. Уламжлалт спортод түшиглэн орчин цагийн спортыг 1921 оноос эхлэн хөгжүүлж ирсэн бөгөөд эдүгээ зарим спортын төрлөөр олимп, дэлхийн түвшинд өрсөлдөх хэмжээнд хөгжөөд байна.

Сүүлийн жилүүдэд спортын амжилт өндөр байгаатай холбоотойгоор иргэдийн спортоор хичээллэх идэвх сонирхол нэмэгдэж, үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллага, спортын клубийн тоо нэмэгдэж байна. Хувийн хэвшил болон төрийн бус байгууллагууд иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлж байгаа ч орон нутагт энэ төрлийн үйлчилгээ эрхлэх нь бага байна.

Цаашид олон улсын жишгийн дагуу иргэдэд төрийн зүгээс үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх эрх зүйн зохицуулалтыг Биеийн тамир, спортын тухай хууль болон бусад хуулиар зохицуулан ажиллаж байна. Үүний үр дүнд биеийн тамир, спортын салбар нь олон улсын жишгийн дагуу зах зээлийн харилцаан дээр хөгжиж, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагаар иргэдэд хүргэх ажил үйлчилгээг гүйцэтгүүлж, төрийн оролцоог багасгах, төр бодлого, зохицуулалт, хяналтын үүрэгтэйгээр ажиллах тогтолцоог бүрдүүлнэ.

Мөн түүнчлэн биеийн тамир, спортын статистик мэдээллийг сайжруулах, өргөжүүлэх, нэгдсэн аргачлал, арга зүй, мэдээллийг бий болгох зорилгоор 2017 онд анх удаа “БИЕЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГО”-ыг улсын хэмжээнд зохион байгуулсан.

III. БИЕЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

Үндсэн үзүүлэлт - 2019



40
НИЙТ БАЙГУУЛЛАГА



77
ИДЭВХИТЭЙ
АЖИЛАДАГ НИЙТ ХОЛБОО




4 626

ЗОХИОН БАЙГУУЛСАН
АРГА ХЭМЖЭЭ

818 386

ХАМРАГДСАН ИРГЭД

Үндсэн үзүүлэлт - 2019



III.1 БИЕЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГА, АЖИЛЛАГЧИД, СПОРТООР ХИЧЭЭЛЛЭГЧИД

Хүүхэд, залуус биеийн тамир, спортоор хичээллэсэнээр бие бялдарын хөгжил тэгшрэхийн зэрэгцээ, биеийн болон сэтгэлийн саад бэрхшээлийг даван туулах чадвартай болж төлөвшдөг. Тиймээс биеийн тамир, спорт нь ямар ч боловсролоос илүүтэйгээр хүнийг нийгэмшүүлэх, төлөвшүүлэгч хүчин зүйл гэж орчин үед үзэж байна. Хүүхэд, залуучуудыг спортоор хичээллүүлэхэд нэн тэргүүнд хүрэлцээтэй, шаардлага хангахуйц заалтай байх нь чухал юм.


Үндэсний Статистикийн хороо, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Биеийн тамир, спортын газар хамтран анх удаа 2017 онд “Биеийн тамир, спортын улсын үзлэг, тооллого”-ыг зохион байгуулсан.

Үзлэг, тооллогын дүнгээр манай улсад биеийн тамир, спортын 31 байгууллага, 985 спорт заал тоологдож, энэ салбарт нийт 4328 хүн ажиллаж байв.

Үндэсний Статистикийн хорооны даргын 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/646 тоот тушаалаар биеийн тамир, спортын статистикийн мэдээллийн багц маягтыг шинэчлэн баталж, үр дүнг жил бүр тархааж байна.


2017 он хүртэл биеийн тамир, спортоор хичээллэгчдийн тоогоор мэдээллийг тархаадаг байсан бол 2018 онд мэдээллийн маягтыг шинэчлэн боловсруулснаар биеийн тамир, спортоор хичээллэдэг тамирчдын тоогоор жилийн мэдээг гаргадаг болсон.

Зураг 1. Биеийн тамир, спортын байгууллагын тоо



Манай улсад 2019 оны байдлаар биеийн тамир, спортын 40 байгууллага, 1016 спорт заалыг 737 ажиллагчидтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Өмнөх онтой харьцуулахад биеийн тамир, спортын байгууллага 2 (4.8%)-оор буурсан байна.

Зураг 2. Спорт заалны тоо




Биеийн тамир, спортын байгууллагад ажиллагчдын 283 (38.4%) нь эмэгтэй, 454 (61.6%) нь эрэгтэй байна. Ажиллагчдын тоог өмнөх онтой харьцуулахад 33 (4.7%)-аар өссөн байна.

Нийт ажиллагчд 737 ажиллагч байгаа бөгөөд эдгээрээс 4 нь хөгжлийн бэрхшээлтэй байна. Энэхүү хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2 нь эмэгтэй байна.

Энэ салбарын ажиллагчдыг албан тушаалаар харвал 49 (6.6%) нь удирдах ажилтан, 73 (9.9%) нь захиргаа, санхүүгийн ажилтан, мөн 73 (9.9%) нь мэргэжилтэн, 187 (25.4%) нь дасгалжуулагч, 50 (6.8%) нь биеийн тамирын арга зүйч, 9 (1.2%) нь эмч, 276 (37.4%) нь үйлчилгээ, аж ахуйн ажилтан, 20 (2.7%) нь бусад ажиллагчид байна.

Зураг 3. Ажиллагчид, албан тушаалаар, хувиар




Биеийн тамир, спортын байгууллагын тоог бүсээр харахад Улаанбаатар хотод 18 (45.0%), Хангайн болон Төвийн бүсэд тус тус 7 (17.5%), баруун бүсэд 5 (12.5%) Зүүн бүсэд 3 (7.5%) байна (Зураг 4).

Мөн Улаанбаатар хотод 279 (27.5%) буюу хамгийн олон спорт заал байгаа бол Зүүн бүсэд 84 (8.3%) буюу спорт заал хамгийн цөөн байна.


Биеийн тамир, спортоор нийт 152567 тамирчин хичээллэж байна. Эдгээр тамирчдыг байршлаар харуулбал биеийн тамир, спортоор хичээллэдэг тамирчдын 3 хүн тутмын нэг нь Хангайн болон Төвийн бүсэд байна.

Зураг 4. Биеийн тамир, спортын үндсэн үзүүлэлтүүд, бүсээр, 2019 он




Мөн тамирчдыг хичээллэж буй спортын төрлөөр нь харахад 36.1 (23.7%) мянга нь үндэсний спортоор, 18.0 (11.8%) мянга нь халз тулаан, хүчний спортоор, 78.0 (51.1%) мянга нь спорт тоглоомоор, 19.2 (12.6%) мянга нь оюуны спортоор, 93 (0.1%) нь пара спортоор, 1.2 (0.8%) мянга нь хэмжигдэхүүний спортоор, 17 нь цэрэгжилтийн спортоор тус тус хичээллэж байна.

Зураг 5. Биеийн тамир, спортоор хичээллэдэг тамирчид, спортын төрлөөр, хувиар



Мөн спортоор хичээллэж байгаа тамирчдыг бүсээр харвал нийт тамирчдын 33.2 хувь нь Хангайн бүсэд, 30.2 хувь нь Төвийн бүсэд, 18.6 хувь нь Баруун бүсэд, 11.1 хувь нь Зүүн бүсэд байна. Харин нийт тамирчдын 6.9 хувь нь Улаанбаатарт байна.

Зураг 6. Биеийн тамир, спортоор хичээллэдэг тамирчид, бүсээр




III.2 ЦОЛТОЙ ТАМИРЧИД, ШҮҮГЧ, ДАСГАЛЖУУЛАГЧИД

Биеийн тамир, спортын тооллогод спортоор хичээллэж буй тамирчдаас цол, зэргийн болзол хангаж үнэмлэх, тэмдгээ авсан иргэдийг аймаг, нийслэлийн хэмжээнд мэдээллийг нэгтгэн гаргаж байна.

Тамирчид, дасгалжуулагч, шүүгчдийн үзүүлэлтийг 2018 оноос өмнө цол, зэрэгтэй тамирчид, дасгалжуулагчид, шүүгчдийн нийт дүнгээр авдаг байсан бол 2018 оноос шинэчилсэн маягтын дагуу зөвхөн цолтой тамирчдын тоогоор гаргадаг болсон.

Манай улсын цол, зэрэгтэй тамирчид, дасгалжуулагчид 2010 оноос хойш буурсаар байгаа ба 2019 онд шинээр 2621 цолтой тамирчид, дасгалжуулагчид бүртгэгдсэн байна.


Зураг 7. Цолтой тамирчид, дасгалжуулагчид



Тайлбар:


- 2017 оны тоо нь биеийн тамир, спортын нэг удаагийн үзлэг тооллогын дүн юм.
- Биеийн тамир, спортын салбарын мэдээг 2018 оноос шинэчилсэн маягтын дагуу цолтой тамирчид, дасгалжуулагчид, шүүгчдийн дүнгээр гаргадаг болсон.
- Биеийн тамир, спортын салбарын тайлант оны жилийн эцсийн статистикийн мэдээллийг гаргахдаа 2019 оноос эхлэн шинэчилсэн маягтын дагуу зөвхөн цолтой тамирчид, дасгалжуулагчид (Цолтой бөхчүүд болон Цолтой сурын харваачид гэсэн шинэ ангилал нэмэгдсэн), шүүгчдийн дүнгээр гаргадаг болсон. Өөрөөр хэлбэл, "СПОРТЫН ЗЭРЭГ" гэдэг ойлголтыг 2019 оноос эхлэн статистикийн жилийн мэдээнд хамруулан ойлгохгүй байхаар заасан. Мөн 2019 оноос эхлэн Биеийн тамир, спортын газрын мэдээллийн сангаас зөвхөн тухайн тайлант оны жилийн эцсийн мэдээллээр жилийн мэдээг тайлагнаж байхаар тусгасан.

Зураг 8. Цолтой тамирчид, дасгалжуулагчид, хүйсээр, дүнд эзлэх хувиар




Шинээр цол авсан тамирчид, дасгалжуулагчдыг хүйсээр авч үзвэл 610 буюу 23.3 хувь нь эмэгтэй байна. Ихэнх нь буюу 2011 (76.7%) нь эрэгтэйчүүд байна. Цол, эрэгтэй тамирчид, дасгалжуулагчдын дүнд эрэгтэйчүүдийн эзлэх хувь тогтмол нэмэгдсээр байна.

Зураг 9. Цолтой тамирчид, дасгалжуулагчид, цолны ангиллаар, дүнд эзлэх хувиар, 2019 он



Зураг 10. Цолтой шүүгчид, цолны ангиллаар, дүнд эзлэх хувиар, 2019 он



Тайлбар:

- 2017 оны биеийн тамир, спортын тооллогын дүнгээр нийт спортоор хичээллэдэг тамирчид, сонирхогчдын тоогоор авсан болно.
- 2019 оноос биеийн тамир, спортоор хичээллэдэг тамирчдын тоогоор авсан.


2019 оны байдлаар улсын хэмжээнд 235 цолтой сурын харваачид, 174 цолтой уяачид, 26347 хурдны морь унаач хүүхэд байна.

Мөн түүнчлэн цолтой шүүгч 140, олон улсын шүүгч 60, улсын шүүгч 80 байна. Цолтой 140 шүүгчээс 38 нь эмэгтэй шүүгч байна.

Зураг 11. Цолтой шүүгчид, 2010-2019 он




Зураг 12. Цолтой шүүгчид, хүйсээр, хувиар, 2019 он



Жил бүр иргэдээ бие бялдрын түвшин тогтоох сорилд хамруулдаг бөгөөд 2019 онд нийт 290.8 мянган хүн энэхүү сорилд хамрагдсан байна. Эдгээрээс 70.0 мянга буюу 24.1 хувь нь эмэгтэйчүүд, 35.2 (12.1%) мянга нь илүүдэл жинтэй байжээ. Илүүдэл жинтэй иргэдийн 18.5 (52.5%) нь эмэгтэйчүүд байна.

Мөн сорилд хамрагдагчдын 61.0 мянга нь А, 93.1 мянга нь В, 71.6 мянга нь С, 44.3 мянга нь D, 20.8 мянга нь F үнэлгээ авчээ.

Зураг 13. Сорилд хамрагдсан иргэдийн авсан үнэлгээ, хувиар, 2019 он



IV. ДҮГНЭЛТ, ЦААШИД АНХААРАХ АСУУДЛУУД

Соёл, урлагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний статистикийн хороо хамтран соёл, шинжлэх, ухаан, спортын салбарын хөгжлийн бодлогыг тодорхойлох, оновчтой шийдвэр гаргахад шаардлагатай статистикийн мэдээллийн чанарыг сайжруулах, ялангуяа мэдээллийн хамрах хүрээг нэмэгдүүлэхэд жил бүр хамтран санаачилгатай ажиллаж байна.

- Манай улсад 2019 оны байдлаар биеийн тамир, спортын 40 байгууллага, 1016 спорт заалыг 737 ажиллагчидтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Өмнөх онтой харьцуулахад биеийн тамир, спортын байгууллага 2 (4.8%)-оор буурсан байна.
- Биеийн тамир, спортын байгууллагад ажиллагчдын 283 (38.4%) нь эмэгтэй, 454 (61.6%) нь эрэгтэй байна. Ажиллагчдын тоог өмнөх онтой харьцуулахад 33 (4.7%)-аар өссөн байна.
- Нийт ажиллагчд 737 ажиллагч байгаа бөгөөд эдгээрээс 4 нь хөгжлийн бэрхшээлтэй байна. Энэхүү хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2 нь эмэгтэй байна.
- Биеийн тамир, спортоор нийт 152567 тамирчин хичээллэж байна. Эдгээр тамирчдыг байршлаар харуулбал биеийн тамир, спортоор хичээллэдэг тамирчдын 3 хүн тутмын нэг нь Хангайн болон Төвийн бүсэд байна.
- Мөн тамирчдыг хичээллэж буй спортын төрлөөр нь харахад 36.1 (23.7%) мянга нь үндэсний спортоор, 18.0 (11.8%) мянга нь халз тулаан, хүчний спортоор, 78.0 (51.1%) мянга нь спорт тоглоомоор, 19.2 (12.6%) мянга нь оюуны спортоор, 93 (0.1%) нь пара спортоор, 1.2 (0.8%) мянга нь хэмжигдэхүүний спортоор, 17 нь цэрэгжилтийн спортоор тус тус хичээллэж байна.
- Мөн спортоор хичээллэж байгаа тамирчдыг бүсээр харвал нийт тамирчдын 33.2 хувь нь Хангайн бүсэд, 30.2 хувь нь Төвийн бүсэд, 18.6 хувь нь Баруун бүсэд, 11.1 хувь нь Зүүн бүсэд байна. Харин нийт тамирчдын 6.9 хувь нь Улаанбаатарт байна.
- Манай улсын цолтой тамирчид, дасгалжуулагчид 2010 оноос хойш буурсаар байгаа ба 2019 онд шинээр 2621 цолтой тамирчид, дасгалжуулагчид бүртгэгдсэн байна.
- Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэдийн 24.1 хувь нь эмэгтэйчүүд, 12.1 хувь нь илүүдэл жинтэй байна.

АНХААРАХ АСУУДЛУУД

- ✓ Соёл, спортын салбарын статистикийн үзүүлэлтүүдийг сум, дүүргийн түвшинд гаргахад бодлогын түвшинд анхаарч ажиллах
- ✓ Орон нутгийн анхан шатны нэгж болон аймаг, нийслэлийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, мэдээлэл хүргэх ажлыг бүсчлэн зохион байгуулах
- ✓ Салбарын мэдээллийн сан бий болгох, хөгжүүлэхэд анхаарч ажиллах

V. ХАВСРАЛТ 1 – ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

ҮНДСЭН ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Биеийн тамир¹ гэж хүн амын идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа юм.

Спорт¹ гэж хүний оюун ухааны болон бие, бялдрын хөгжлийг дэмжсэн идэвхтэй үйлдлийг ойлгоно.

Тамирчин¹ гэж спортын сургалт-дасгалжуулалтаар бэлтгэгдэн, спортын тэмцээнд оролцдог этгээд юм.

Дасгалжуулагч¹ гэж спортын сургалт-дасгалжуулалт, спортын тэмцээнд оролцуулах үйл ажиллагааг удирдаж байгаа этгээд юм.

Спортын барилга, байгууламж¹ гэж спортоор хичээллэх, спортын тэмцээн зохион байгуулах зориулалт бүхий байгууламж, түүний дэд бүтэц юм.

Спорт заал, гадаа талбай гэдэгт биеийн тамир, спортоор хичээллэгч, тамирчин, дасгалжуулагчийн идэвхтэй хөдөлгөөн, бэлтгэл, сургуулилт хийх талбайн стандарт, техник, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байгууламж, заал, талбайг хамруулна.

Спортын холбоо¹ гэж нэг, эсхүл хэд хэдэн спортын төрлийг хөгжүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага юм.

Спортын клуб¹ гэж идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх, сургалт-дасгалжуулалтын чиглэлээр үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий хуулийн этгээд юм.

Спортын арга хэмжээ гэдэгт спортын бүх төрлөөр хичээллэх, бэлтгэл хийх, тэмцээн уралдаан зохион байгуулах болон спортын бусад арга хэмжээг хамруулж ойлгоно.

- **Спортын тэмцээн**¹ гэдэгт тогтоосон дүрмийн дагуу өрсөлдөх үйл явцыг ойлгоно.
- **Спортын наадам**¹ гэдэгт нэгдсэн хэлбэрээр зохион байгуулж байгаа спортын тэмцээн, соёл урлагийн арга хэмжээний нэгдлийг ойлгоно.

Үндэсний спорт¹ гэж ард түмний уламжлал, зан заншилд тулгуурлан хөгжсөн үндэсний онцлог шинжийг агуулсан спорт юм.

¹ Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хуулийн 4 дүгээр зүйл

VI. ХАВСРАЛТ 2 – ХҮСНЭГТҮҮД

1. БИЕЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАГЧИД, бус, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	2010			2011			2012			2013			2014		
	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй
Бүгд	460	176	284	461	171	290	513	196	317	544	213	331	568	224	344
Баруун бүс	83	26	57	93	32	61	97	33	64	100	41	59	105	36	69
Баян-Өлгий	9	1	8	18	5	13	18	5	13	20	7	13	19	6	13
Говь-Алтай	19	7	12	19	7	12	19	7	12	21	8	13	21	8	13
Завхан	15	4	11	15	5	10	16	5	11	17	10	7	18	5	13
Увс	17	5	12	18	7	11	18	7	11	19	8	11	24	9	15
Ховд	23	9	14	23	8	15	26	9	17	23	8	15	23	8	15
Хангайн бүс	107	42	65	106	38	68	132	51	81	145	60	85	141	64	77
Архангай	12	3	9	13	4	9	14	2	12	15	7	8	15	7	8
Баянхонгор	14	8	6	14	8	6	15	8	7	17	7	10	17	7	10
Булган	19	8	11	20	10	10	26	11	15	25	11	14	24	15	9
Орхон	25	8	17	25	8	17	33	12	21	37	14	23	32	12	20
Өвөрхангай	26	11	15	22	8	14	23	8	15	27	9	18	28	11	17
Хөвсгөл	11	4	7	12	-	12	21	10	11	24	12	12	25	12	13
Төвийн бүс	114	45	69	109	40	69	115	42	73	128	42	86	142	49	93
Говьсүмбэр	14	5	9	11	5	6	15	5	10	17	-	17	20	8	12
Дархан-Уул	23	7	16	23	7	16	23	7	16	26	8	18	34	7	27
Дорноговь	14	6	8	12	4	8	12	5	7	11	4	7	11	4	7
Дундговь	13	5	8	12	4	8	13	4	9	13	4	9	13	3	10
Өмнөговь	13	6	7	13	6	7	13	6	7	19	11	8	22	12	10
Сэлэнгэ	17	6	11	19	6	13	18	7	11	21	7	14	21	7	14
Төв	20	10	10	19	8	11	21	8	13	21	8	13	21	8	13
Зүүн бүс	47	19	28	48	20	28	60	26	34	62	27	35	61	26	35
Дорнод	14	5	9	14	6	8	18	7	11	18	7	11	18	7	11
Сүхбаатар	15	5	10	15	5	10	23	9	14	25	9	16	24	8	16
Хэнтий	18	9	9	19	9	10	19	10	9	19	11	8	19	11	8
Улаанбаатар	109	44	65	105	41	64	109	44	65	109	43	66	119	49	70

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

¹Биеийн тамир, спортын нэг удаагийн үзлэг, тооллогын дүн

2. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАГЧИД, БУС АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР

Аймаг, нийслэл	2015			2016			2017 ¹			2018			2019		
	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй
Бүгд	565	215	350	559	223	336	5 144	2 240	2 904	704	215	489	737	283	454
Баруун бүс	101	33	68	98	33	65	702	285	417	107	32	75	103	39	64
Баян-Өлгий	20	6	14	20	6	14	160	52	108	18	6	12	18	6	12
Говь-Алтай	18	5	13	18	5	13	100	39	61	19	5	14	19	6	13
Завхан	16	6	10	16	6	10	121	58	63	17	-	17	17	6	11
Увс	24	8	16	19	8	11	170	72	98	28	10	18	25	10	15
Ховд	23	8	15	25	8	17	151	64	87	25	11	14	24	11	13
Хангайн бүс	131	53	78	142	62	80	1 659	711	948	204	66	138	167	64	103
Архангай	15	7	8	19	9	10	149	57	92	20	8	12	21	7	14
Баянхонгор	14	6	8	18	10	8	129	62	67	27	13	14	26	11	15
Булган	22	10	12	27	11	16	107	50	57	25	12	13	30	14	16
Орхон	32	12	20	30	11	19	161	84	77	30	12	18	28	11	17
Өвөрхангай	25	8	17	25	9	16	111	20	91	35	11	24	35	11	24
Хөвсгөл	23	10	13	23	12	11	186	60	126	67	10	57	27	10	17
Төвийн бүс	133	53	80	126	49	77	816	378	438	181	47	134	172	78	94
Говьсүмбэр	18	8	10	17	8	9	29	14	15	17	7	10	17	7	10
Дархан-Уул	32	9	23	23	7	16	233	119	114	32	12	20	23	7	16
Дорноговь	12	8	4	15	6	9	82	35	47	25	12	13	26	11	15
Дундговь	14	4	10	13	4	9	75	36	39	15	5	10	15	5	10
Өмнөговь	19	8	11	17	7	10	123	56	67	15	6	9	14	6	8
Сэлэнгэ	19	6	13	19	7	12	152	61	91	56	-	56	56	32	24
Төв	19	10	9	22	10	12	122	57	65	21	5	16	21	10	11
Зүүн бүс	80	27	53	67	26	41	339	128	211	63	21	42	79	33	46
Дорнод	20	8	12	18	7	11	120	46	74	18	5	13	18	6	12
Сүхбаатар	30	11	19	30	11	19	97	42	55	26	9	17	42	20	22
Хэнтий	30	8	22	19	8	11	122	40	82	19	7	12	19	7	12
Улаанбаатар	120	49	71	126	53	73	1 628	738	890	149	49	100	216	69	147

Эхүүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

¹2017 онд Биеийн тамир, спортын нэг удаагийн үзлэг, тооллого явагдсан. Тооллогоор ажиллагчдын тоонд тухайн жилд заал, талбай хариуцан ажиллаж буй ерөнхий боловсролын сургуулийн багш, дасгалжуулагч, зохион байгуулагчдын тоог оруулж тоолсон. Харин 2018 онд Биеийн тамир, спортын салбарын статистикийн маягтыг шинэчлэн баталсан. Шинэчлэгдсэн маягтаар аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхэлж буй ажиллагчдын мэдээллийг оруулдаг болсон.

3. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГА, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017 ¹	2018	2019
Бүгд	31	32	31	31	31	31	31	31	42	40
Баруун бүс	5	5	5	5	5	5	5	5	6	5
Баян-Өлгий	1	1	1	1	1	1	1	1	1	1
Говь-Алтай	1	1	1	1	1	1	1	1	1	1
Завхан	1	1	1	1	1	1	1	1	1	1
Увс	1	1	1	1	1	1	1	1	1	1
Ховд	1	1	1	1	1	1	1	1	2	1
Хангайн бүс	6	7	6	6	6	6	6	6	8	7
Архангай	1	1	1	1	1	1	1	1	1	1
Баянхонгор	1	1	1	1	1	1	1	1	1	1
Булган	1	2	1	1	1	1	1	1	1	1
Орхон	1	1	1	1	1	1	1	1	1	1
Өвөрхангай	1	1	1	1	1	1	1	1	1	1
Хөвсгөл	1	1	1	1	1	1	1	1	3	2
Төвийн бүс	7	7	7	7	7	7	7	7	11	7
Говьсүмбэр	1	1	1	1	1	1	1	1	1	1
Дархан-Уул	1	1	1	1	1	1	1	1	4	1
Дорноговь	1	1	1	1	1	1	1	1	1	1
Дундговь	1	1	1	1	1	1	1	1	2	1
Өмнөговь	1	1	1	1	1	1	1	1	1	1
Сэлэнгэ	1	1	1	1	1	1	1	1	1	1
Төв	1	1	1	1	1	1	1	1	1	1
Зүүн бүс	3	3	3	3	3	3	3	3	3	3
Дорнод	1	1	1	1	1	1	1	1	1	1
Сүхбаатар	1	1	1	1	1	1	1	1	1	1
Хэнтий	1	1	1	1	1	1	1	1	1	1
Улаанбаатар	10	10	10	10	10	10	10	10	14	18

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

¹Биеийн тамир, спортын нэг удаагийн үзлэг, тооллогын дүн

4. БИЕИЙН ТАМИР, СПОРТООР ХИЧЭЭЛЛЭДЭГ ТАМИРЧИД, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017 ¹	2018 ²	2019
Бүгд	729 317	917 912	712 303	805 490	1 200 987	1 383 990	784 733	1 118 400	147 216	152 567
Баруун бүс	135 404	156 612	131 767	130 559	116 174	140 694	123 370	242 000	30 670	28 404
Баян-Өлгий	22 152	22 861	24 424	18 766	19 018	19 997	19 417	39 902	9 667	10 695
Говь-Алтай	14 016	17 578	17 578	25 010	20 908	28 329	31 576	26 670	5 573	643
Завхан	41 467	42 671	21 590	17 014	25 900	34 240	13 694	46 457	3 515	9 440
Увс	41 716	53 241	26 884	30 566	24 878	39 993	19 713	48 838	11 053	6 719
Ховд	16 053	20 261	41 291	39 203	25 470	18 135	38 970	80 133	862	907
Хангайн бүс	184 393	205 029	149 072	170 298	192 676	353 033	209 717	268 608	46 212	50 693
Архангай	12 503	12 572	21 059	15 660	47 226	47 216	11 897	34 861	4 516	3 166
Баянхонгор	10 360	11 020	5 819	3 290	3 290	29 690	19 950	43 312	9 759	9 976
Булган	34 995	39 654	20 454	25 690	22 284	27 291	27 178	27 335	3 965	4 759
Орхон	32 365	32 407	41 241	42 900	41 310	52 788	49 557	48 100	4 351	6 807
Өвөрхангай	10 350	14 189	10 507	15 585	13 221	127 280	54 479	41 174	7 230	8 565
Хөвсгөл	83 820	95 187	49 992	67 173	65 345	68 768	46 656	73 826	16 391	17 420
Төвийн бүс	164 564	190 136	222 101	255 854	238 771	187 390	132 270	176 766	30 172	46 020
Говьсүмбэр	4 457	4 568	10 609	10 971	15 010	19 029	19 859	13 307	2 748	3 189
Дархан-Уул	30 754	31 389	29 434	26 583	27 836	34 240	22 720	19 215	3 690	2 414
Дорноговь	8 980	30 414	32 067	32 066	32 066	7 658	14 569	16 253	2 937	2 789
Дундговь	34 449	35 930	44 774	52 541	53 737	14 442	18 636	28 541	13 445	20 299
Өмнөговь	26 027	26 329	16 424	71 754	21 208	20 830	19 996	23 918	327	455
Сэлэнгэ	4 808	3 780	29 210	3 570	30 545	30 417	4 240	28 456	2 241	820
Төв	55 089	57 726	59 583	58 369	58 369	60 774	32 250	47 076	4 784	16 054
Зүүн бүс	69 593	73 955	34 000	27 629	29 215	42 735	42 018	107 580	17 257	16 991
Дорнод	31 501	32 552	10 096	8 371	8 371	8 520	9 432	62 783	6 311	8 304
Сүхбаатар	18 120	18 702	8 306	3 158	4 744	24 938	11 420	12 335	6 832	3 313
Хэнтий	19 972	22 701	15 598	16 100	16 100	9 277	21 166	32 462	4 114	5 374
Улаанбаатар	175 363	292 180	175 363	221 150	624 151	660 138	277 358	323 446	22 905	10 459

Эх үүсвэр: Болловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

¹Биеийн тамир, спортын нэг удаагийн үзлэг, тооллогын дүн

²2018 оноос биеийн тамир, спортоор хичээллэдэг тамирчдын тоогоор авсан.

5. СПОРТ ЗААЛ, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017 ¹	2018	2019
Бүгд	661	703	704	757	734	758	850	985	1 000	1 016
Баруун бүс	123	137	142	149	149	132	154	165	165	167
Баян-Өлгий	11	23	25	28	29	30	31	33	33	33
Говь-Алтай	25	24	24	28	28	20	28	28	28	28
Завхан	31	31	31	31	31	20	30	33	33	33
Увс	30	30	33	33	33	33	35	38	38	40
Ховд	26	29	29	29	28	29	30	33	33	33
Хангайн бүс	167	168	164	179	185	196	204	220	226	233
Архангай	31	31	31	33	34	34	34	26	27	28
Баянхонгор	24	24	24	32	32	31	31	42	42	42
Булган	22	22	22	24	23	24	24	32	32	34
Орхон	22	22	22	24	26	28	33	33	33	33
Өвөрхангай	32	33	29	29	33	34	37	39	41	44
Хөвсгөл	36	36	36	37	37	45	45	48	51	52
Төвийн бүс	175	178	181	168	167	171	199	244	247	253
Говьсүмбэр	9	9	9	10	9	9	9	10	10	10
Дархан-Уул	28	28	29	29	29	29	29	47	47	47
Дорноговь	21	22	22	21	21	21	21	29	29	32
Дундговь	21	21	22	1	1	1	27	27	28	29
Өмнөговь	24	24	24	24	23	24	26	35	35	35
Сэлэнгэ	33	34	34	42	43	43	43	45	45	45
Төв	39	40	41	41	41	44	44	51	53	55
Зүүн бүс	61	64	61	67	67	41	81	84	84	84
Дорнод	19	21	21	24	24	24	30	31	31	31
Сүхбаатар	13	13	13	16	16	16	16	21	21	21
Хэнтий	29	30	27	27	27	1	35	32	32	32
Улаанбаатар	135	156	156	194	166	218	212	272	278	279

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

¹Биеийн тамир, спортын нэг удаагийн үзлэг, тооллогын дүн

6. ЦОЛТОЙ ТАМИРЧИД, ДАСГАЛЖУУЛАГЧИД, ШҮҮГЧИД, БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР

Аймаг, нийслэл	2017 ¹											
	Цолтой тамирчид, дасгалжуулагчид					Цолтой шүүгчид						
	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй	Гавьяат тамирчид	Гавьяат дасгалжуулагч, багш	Олон улсын мастер	Спортын мастер	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй	Олон улсын шүүгч	Улсын шүүгч
БҮГД	20 383	6 391	13 992	127	62	566	3 189	160	33	127	14	146
Баруун бүс	3 021	833	2 188	1	3	43	409	35	6	29	2	33
Баян-Өлгий	426	66	360	1	1	14	84	5	-	5	-	5
Говь-Алтай	485	134	351	-	-	3	57	5	2	3	-	5
Завхан	326	101	225	-	-	5	60	3	-	3	1	2
Увс	1 146	400	746	-	1	13	73	12	4	8	1	11
Ховд	638	132	506	-	1	8	135	10	-	10	-	10
Хангайн бүс	4 188	1 330	2 858	19	6	74	644	16	1	15	-	16
Архангай	976	259	717	7	1	6	59	5	-	5	-	5
Баянхонгор	574	203	371	4	2	4	79	-	-	-	-	-
Булган	488	158	330	1	-	9	84	1	-	1	-	1
Орхон	734	279	455	7	3	40	251	7	1	6	-	7
Өвөрхангай	808	225	583	-	-	6	124	3	-	3	-	3
Хөвсгөл	608	206	402	-	-	9	47	-	-	-	-	-
Төвийн бүс	5 886	1 776	4 110	22	17	100	897	31	6	25	3	28
Говьсүмбэр	773	323	450	-	1	7	51	-	-	-	-	-
Дархан-Уул	1 515	533	982	5	3	37	219	9	4	5	1	8
Дорноговь	896	214	682	1	1	24	248	12	1	11	1	11
Дундговь	1 040	235	805	-	-	6	77	-	-	-	-	-
Өмнөговь	488	141	347	-	-	3	128	1	-	1	-	1
Сэлэнгэ	368	101	267	6	7	8	91	3	-	3	1	2
Төв	806	229	577	10	5	15	83	6	1	5	-	6
Зүүн бүс	2 102	631	1 471	7	7	35	244	8	2	6	-	8
Дорнод	757	233	524	4	2	9	56	2	-	2	-	2
Сүхбаатар	649	181	468	-	1	16	113	1	-	1	-	1
Хэнтий	696	217	479	3	4	10	75	5	2	3	-	5
Улаанбаатар	5 186	1 821	3 365	78	29	314	995	70	18	52	9	61

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

¹ 2017 онд Биеийн тамир, спортын нэг удаагийн үзлэг, тооллого явагдсан.

7. ЦОЛТОЙ ТАМИРЧИД, ДАСГАЛЖУУЛАГЧИД, ШҮҮГЧИД, БУС, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР

Аймаг, нийслэл	2018 ¹										
	Цолтой тамирчид, дасгалжуулагчид					Цолтой шүүгчид					
	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй	Олон улсын мастер	Спортын мастер	Спортын дэд мастер	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй	Олон улсын шүүгч	Улсын шүүгч
Бүгд	6 773	2 542	4 231	909	3 353	2 511	447	109	338	51	396
Баруун бүс	967	291	676	110	435	422	32	7	25	4	28
Баян-Өлгий	233	25	208	15	102	116	7	-	7	2	5
Говь-Алтай	195	72	123	23	90	82	6	3	3	-	6
Завхан	75	57	18	11	35	29	3	2	1	1	2
Увс	262	83	179	38	112	112	6	1	5	1	5
Ховд	202	54	148	23	96	83	10	1	9	-	10
Хангайн бүс	1 201	344	857	141	628	432	66	17	49	6	60
Архангай	193	44	149	27	99	67	33	6	27	2	31
Баянхонгор	157	48	109	14	82	61	7	-	7	-	7
Булган	172	43	129	24	102	46	4	2	2	-	4
Орхон	287	63	224	26	153	108	6	3	3	2	4
Өвөрхангай	179	75	104	22	81	76	10	4	6	2	8
Хөвсгөл	213	71	142	28	111	74	6	2	4	-	6
Төвийн бүс	1 294	391	903	137	699	458	105	30	75	7	98
Говьсүмбэр	55	19	36	5	32	18	1	-	1	1	-
Дархан-Уул	264	85	179	32	148	84	9	-	9	3	6
Дорноговь	179	47	132	16	90	73	10	2	8	-	10
Дундговь	172	51	121	13	88	71	3	-	3	-	3
Өмнөговь	152	46	106	10	93	49	6	2	4	-	6
Сэлэнгэ	260	74	186	35	137	88	7	1	6	2	5
Төв	212	69	143	26	111	75	69	25	44	1	68
Зүүн бүс	557	192	365	69	244	244	23	1	22	4	19
Дорнод	219	78	141	25	117	77	4	1	3	1	3
Сүхбаатар	151	49	102	17	66	68	3	-	3	1	2
Хэнтий	187	65	122	27	61	99	16	-	16	2	14
Улаанбаатар	2 754	1 324	1 430	452	1 347	955	221	54	167	30	191

Эхүүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

¹Биеийн тамир, спортын салбарын 2018 оны мэдээг цол, зэрэгтэй тамирчид, дасгалжуулагчид, шүүгчдийн дүнгээр гаргасан. 2017 оноос өмнө сум, баг, байгууллагын түвшинд зохион байгуулсан тэмцээн, бусад биеийн тамирын арга хэмжээнд хамрагдсан иргэдийг бүртгэн мэдээллийг цуглуулдаг байсан. Харин 2018 онд Биеийн тамир, спортын салбарын статистикийн маягтыг шинэчлэн баталсан ба зөвхөн аймаг, дүүргийн аварга шалгаруулах тэмцээн болон түүнээс дээш шатлалын тэмцээнд оролцсон тамирчдын хүрээнд мэдээллийг цуглуулахаар тусгасан. Учир нь "Биеийн тамир, спортын тухай хууль"-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь хэсэгт зааснаар "Тамирчин гэж спортын сургалт-дасгалжуулагчаар бэлтгэгдсэн, спортын тэмцээнд оролцдог этгээдийг" ойлгоно гэж тодорхойлсон байдаг.

8. ЦОЛТОЙ ТАМИРЧИД, ДАСГАЛЖУУЛАГЧИД, ШҮҮГЧИД, БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР

Аймаг, нийслэл	2019 ¹												
	Цол, зэрэгтэй тамирчид, дасгалжуулагчид					Цол, зэрэгтэй шүүгчид							
	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй	Олон улсын мастер	Спортын мастер	Спортын дэд мастер	Цолтой бөхчүүд	Цолтой сурын харваачид	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй	Олон улсын шүүгч	Улсын шүүгч
Бүгд	2 621	610	2 011	251	755	945	435	235	140	38	102	60	80
Баруун бүс	555	87	468	19	149	199	118	70	8	2	6	-	8
Баян-Өлгий	82	8	74	5	22	32	18	5	1	-	1	-	1
Говь-Алтай	117	23	94	3	32	40	24	18	3	1	2	-	3
Завхан	113	15	98	2	24	30	26	31	1	-	1	-	1
Увс	117	25	92	7	39	37	26	8	2	1	1	-	2
Ховд	126	16	110	2	32	60	24	8	1	-	1	-	1
Хангайн бүс	511	125	386	47	119	161	123	61	14	5	9	2	12
Архангай	81	16	65	6	26	22	19	8	-	-	-	-	-
Баянхонгор	57	17	40	3	8	6	23	17	-	-	-	-	-
Булган	67	18	49	9	9	26	20	3	3	-	3	2	1
Орхон	117	31	86	12	39	54	7	5	4	2	2	-	4
Өвөрхангай	102	20	82	9	18	31	27	17	2	1	1	-	2
Хөвсгөл	87	23	64	8	19	22	27	11	5	2	3	-	5
Төвийн бүс	575	128	447	44	156	187	129	59	19	6	13	2	17
Говьсүмбэр	12	3	9	2	1	2	5	2	-	-	-	-	-
Дархан-Уул	115	33	82	11	38	52	9	5	4	-	4	1	3
Дорноговь	76	13	63	5	15	16	19	21	2	-	2	-	2
Дундговь	92	22	70	1	40	22	21	8	3	2	1	-	3
Өмнөговь	82	14	68	7	17	34	20	4	-	-	-	-	-
Сэлэнгэ	110	18	92	16	27	33	25	9	9	4	5	1	8
Төв	88	25	63	2	18	28	30	10	1	-	1	-	1
Зүүн бүс	262	56	206	14	74	86	65	23	2	1	1	-	2
Дорнод	94	22	72	5	26	30	23	10	1	1	-	-	1
Сүхбаатар	65	18	47	4	16	21	17	7	-	-	-	-	-
Хэнтий	103	16	87	5	32	35	25	6	1	-	1	-	1
Улаанбаатар	718	214	504	127	257	312	-	22	97	24	73	56	41

Эхүүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

¹Биеийн тамир, спортын салбарын тайлант оны жилийн эцсийн статистикийн мэдээллийг гаргахдаа 2019 оноос эхлэн шинэчилсэн маягтын дагуу зөвхөн цолтой тамирчид, дасгалжуулагчид (Цолтой бөхчүүд болон Цолтой сурын харваачид гэсэн шинэ ангилал нэмэгдсэн), шүүгчдийн дүнгээр гаргадаг болсон. Өөрөөр хэлбэл, "СПОРТЫН ЗЭРЭГ" гэдэг ойлголтыг 2019 оноос эхлэн статистикийн жилийн мэдээнд хамруулан ойлгохгүй байхаар заасан. Мөн 2019 оноос эхлэн Биеийн тамир, спортын газрын мэдээллийн сангаас зөвхөн тухайн тайлант оны жилийн эцсийн мэдээлэлээр жилийн мэдээг тайлагнаж байхаар тусгасан.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- ЮНЕСКО, БУИТ, Ж.Эрхэмтөгс, доктор (Ph.D), дэд профессор, “Бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийн үнэлгээ, төлөвлөлтийн арга зүй”, УБ, 2019
- ЮНЕСКО, БУИТ, Ж.Эрхэмтөгс, доктор (Ph.D), дэд профессор, “Бүтээлч үйлдвэрлэл хөгжүүлэх онол” практикийн асуудал, УБ, 2019
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Үндэсний статистикийн хороо, Биеийн тамир, спортын газар, “Биеийн тамир, спортын улсын үзлэг, тооллого”-ын үр дүн
- Биеийн тамир, спортын салбарын 2019 оны жилийн мэдээ

----- оОо -----